

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2018 оны 01 дүгээр сарын
19-ны өдрийн А/04 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

**“Хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох үйл явцын өнөөгийн байдал,
тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт
эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж**

Зорилго:

Иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох асуудалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, суурь судалгаатай болоход эрдэм шинжилгээний бага хурлын зорилго оршино.

Сэдэв:

- Даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтооход баримтлах хууль, эрхзүйн орчин, түүний нөлөөлөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;
- Даатгуулагч (иргэн)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтоож буй үйл явц (бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үр дүн)-ын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам;
/Эрдэм шинжилгээний бага хуралд оролцогч нь өгөгдсөн сэдвийн хүрээнд аль нэгийг сонгон оролцож болно/

Зохион байгуулагч:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Хөдөлмөр, Орчны эрүүл мэндийн институт

Зохион байгуулах өдөр: 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Оролцогчид:

Төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн магистрант, докторант, эрдэмтэн, судлаач

Хурал зохион байгуулах байршил:

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо Бага тойруу 13/1
Нийгмийн даатгалын ерөнхий газрын хурлын танхим 702 тоот

Санхүүжүүлэгч:

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс

Илтгэлд тавигдах шаардлага:

а/ Агуулгын ерөнхий шаардлага

- Нийгмийн хамгаалал, хууль эрхзүй, менежментийн шинжлэх ухааны тодорхой арга зүйн үндэслэлтэй байх;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримт материал хавсаргаж баталгаажуулах;

- Судалгаа шинжилгээний онол, арга хэрэгслүүдийг ашиглах;
- Ишлэл зүүлтийн заалт бичих;
- Ашигласан ном, судалгааны ажил, эх материалын жагсаалт бичих;
- Удиртгал, илтгэлийн агуулга, ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг заавал хийсэн байх;
- Хэрэгжиж болохуйц шинэлэг санаа дэвшүүлсэн байх;

б/ Илтгэл боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага

- Үсгийн фонд- Arial;
 - Үсгийн хэмжээ-12;
 - Мөр хоорондын зай -1.5;
 - Хүрээ- Normal;
 - Хуудасны тоо- 8-аас доошгүй;
- Нүүр хуудсанд илтгэлийн нэр, илтгэгчийн овог, нэр, албан тушаал, мэргэжил, зэрэг цол, сэдвийн нэрийг тэмдэглэх зэрэг шаардлагыг хангасан байна

Илтгэлийн хураангуйг Arial font-оор үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай Single, хүрээ-Normal, А4 хэмжээний 2-3 нүүр, 500-600 үгэнд багтаан бичих /Илтгэлийн болон зохиогчийн нэр, хаяг үгийн тоонд орохгүй/;

Илтгэлийн танилцуулгыг Power point-оор 15 минутын хугацаанд багтаан танилцуулахаар бэлтгэнэ.

Илтгэл хүлээн авах хугацаа:

Илтгэлийг хураангуйн хамт 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаанд jargalsaikhan@mnum.mn, Gansuh.ts@ndaatgal.mn и-мэйл хаягаар хүлээн авна.

Холбоо барих хаяг:НДЕГ-ын дэргэдэх ЭХМТК-ын 603 тоот өрөө, Ц.Гансүх
АШУҮИС-ийн НЭМС-ийн 340 тоот өрөө, Г.Жаргалсайхан
Утасны дугаар: 99175977, И-мэйл хаяг: gansuh.ts@ndaatgal.mn
88009879, И-мэйл хаяг: jargalsaikhan@mnum.mn

Шалгуур үзүүлэлт:

- Судалгааны онол арга зүйн түвшин
- Судалгааны ажлын шинэлэг санаа
- Судалгааны арга аргачлал, боловсруулалт
- Судалгааны мэдээлэл үнэн бодит нотолгоонд суурилсан, баримтаар баталгаажсан байдал
- Практик ач холбогдол
- Илтгэх ур чадвар зэрэг үзүүлэлтээр дүгнэнэ.


Илтгэл шалгаруулах:

Илтгэлийг 2 үе шаттай шалгаруулна. Үүнд:

1. Оролцогчдын ирүүлсэн илтгэл, илтгэлийн хураангуйтай ажлын хэсгийн гишүүн тус бүр танилцаж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгөх замаар шалгаруулна.
2. Шалгарсан илтгэлийг Эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлж, оноогоор дүгнэн шилдэг 3 илтгэлийг шалгаруулна.

Шагналын сан:

- | | |
|------------------------|--|
| 1. Тэргүүн байр-1, | өргөмжлөл, 1 000 000 төгрөгийн мөнгөн шагнал |
| 2. Дэд байр-1, | өргөмжлөл, 500 000 төгрөгийн мөнгөн шагнал |
| 3. Гуравдугаар байр-1, | өргөмжлөл, 300 000 төгрөгийн мөнгөн шагнал |
- Хурлын үр дүн:**



Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын хууль эрх зүйн орчин, тогтолцооны өнөөгийн байдал, ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс үүдэх хөдөлмөрийн чадвар алдалт, түүнээс урьдчилан сэргийлэх, сэргээн засах тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар холбогдох мэргэжилтэн, судлаачдын анхаарлыг татах, шинжлэх ухаан, нотолгоонд суурилсан судалгаатай болох.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ КОМИСС

